



НИЙСЛЭЛИЙН
АГААРЫН ЧАНАРЫН АЛБАНЫ ДАРГЫН
ТУШААЛ

2013 оны 11 сарын 28 өдөр

Дугаар 5190

Улаанбаатар хот

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын "Төсвийн тухай" хуулийн 16 дугаар зүйлийн 16.1, 16.5 дахь заалт, Нийслэлийн Засаг даргын 2013 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн "Ажлын хэсэг байгуулах тухай" А/442 дугаартай захирамж, 2013 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн "Ажил гүйцэтгэх" АЧА/2013/11 тоот гэрээ, 2013 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн "Хамтран ажиллах" 02 тоот гэрээ, Албаны даргын дэргэдэх 2013 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн 06 тоот хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Сонгинохайрхан дүүргийн 03 дугаар хороонд байрлуулсан Агаарын чанарт хэмжилт хийх суурин харуулыг цахилгааны эх үүсвэрт холбоход шаардлагатай 0,4 кВт-ын АВВГ 4*25-ын 150 метрийн урт тэжээлийн кабелийг газар дор ухаж байршуулах, цахилгааны эх үүсвэрт холбох гэрээний үнэ болох 4 100 000 /дөрвөн сая нэг зуун мянга/ төгрөгийн ажлын гүйцэтгэлд хяналт тавьж, албаны удирдлагад тайлагнан ажиллахыг Хяналт, үнэлгээний хэлтэс /Д.Даваадорж/-т даалгасугай.

2. Баянзүрх дүүргийн 08 дугаар хороо, Амгалангийн эцэст байрлах "Өнө-Амгалан" төвийн эзэмшлийн №1480 тоот дугаартай 0,4 кВт-ын бууруулах станцыг хамтран эзэмшиж, ашиглах чиглэлээр байгуулсан гэрээний үнэ болох 2 000 000 /хоёр сая/ төгрөгийн ажлын гүйцэтгэлд хяналт тавьж, албаны удирдлагад тайлагнан ажиллахыг Хяналт, үнэлгээний хэлтэс /Д.Даваадорж/-т даалгасугай.

3. Тус гэрээт ажлуудын үнэ болох 6,100,000 /зургаан сая нэг зуун мянга/ төгрөгийг урсгал засварын зардлаас гаргахыг нягтлан бодогч /П.Ариунаа/-д зөвшөөрсүгэй.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



ХАНЧ.БАТСАЙХАН

My documents tushaal

1157500179